



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 10 өдөр

Дугаар 1952

Мандалговь

Түгээмэл тархацтай ашигт малтмалын  
хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тухай

Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.5, 14 дүгээр зүйлийн 14.7 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 38 дугаар тогтоол, Ашигт малтмал газрын тосны газрын дүгнэлт, Сайнцагаан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын санал зэргийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дундговь аймгийн Сайнцагаан сумын нутагт түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг хавсралтад заасан аж ахуйн нэгжид тогтоосон хэмжээ, солбицолын дагуу 3 жилийн хугацаагаар олгосугай.

2. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээг аж ахуйн нэгжид хуулийн дагуу олгон, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Н.Эрдэнэ-Очир), Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат), тухайн сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 25, 26, 27 дугаар зүйлүүдэд заасан тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нийтлэг болон байгаль орчныг хамгаалах үүргээ хэрэгжүүлж ажиллахыг аж ахуйн нэгжийн удирдлагуудад үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

4822100728